



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 дугаар сарын 05 өдөр Дугаар 21

Хэрлэн сум

XXI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 21 дүгээр хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 17:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 91,6 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Тусгаарлан ажиглах байрны бэлтгэл ажлын талаар танилцуулах,  
*Эрүүл мэндийн газар*

2.Багийн иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулах эсэх талаар хэлэлцэх,  
*АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс*

3.Шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаа буюу 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хэвийн явуулахад шаардагдах зардлыг танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*


4.Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт агентлагуудаас нэмэлтээр томилогдон ажиллаж байгаа албан хаагчдыг цаашид ажиллуулах эсэх талаар хэлэлцэх,

*АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс*

5.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичиг танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

- Матад сумын Онцгой комиссоос ирүүлсэн хүсэлт
- “МСJ mining” ХХК хүсэлт
- “Степ голд” ХХК хүсэлт
- “Мобиком ХХК” хүсэлт
- “Спейшл майнинг сервис” ХХК хүсэлт
- “ТИ ЭМ БИ ЭН” ХХК хүсэлт
- “Хөдөлмөр халамж үйлчилгээний газар” хүсэлт
- “ЭРДЭНЭДРИЛИНГ” ХХК хүсэлт
- “МЭЗ” ХХК хүсэлт

1 /  / М.Бадамсүрэн  
*Д.Баттулга* Д.Баттулга

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

1.1.Тусгаарлан ажиглах байрны нөөцөд бүртгэсэн байгаа зочид буудлын удирдлагуудтай шаардлагатай нөхцөлд иргэдийг тусгаарлах талаар уулзалт зохион байгуулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

Хоёр.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

2.1.Сум, багийн иргэдийн нийтийн хурлыг сумын Соёлын төвд зохион байгуулах, иргэдийн гарах хөдөлгөөнийг зохицуулах, халдвар хамгааллын дэглэмийг баримталж ажиллах тухай сумын Засаг дарга нарт албан бичгээр чиглэл хүргүүлэхийг,

Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа-д:



2.2.Соёлын төвгүй Гурванзагал, Матад сумдад Ерөнхий боловсролын сургуулийн спорт зааланд Сум, багийн иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулах талаар Гурванзагал, Матад сумын Ерөнхий боловсролын сургуулиудын удирдлагуудад албан бичгээр чиглэл хүргүүлэхийг,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-т:

2.3.Хэрлэн сумын Багийн иргэдийн нийтийн хурлыг 1-р багт "ДБЭХС" ХХК-ийн спорт зааланд, 2,3-р багт 2-р багийн спорт зааланд, 4-р багт Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын спорт зааланд, 5-р багт "ДБЭХС" ХХК-ийн спорт зааланд, 6-р багт Хэрлэн номин бизнес төвийн спорт зааланд, 7-р багт Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн спорт зааланд, 8-р багт Төмөрзамын спорт зааланд, 9-р багт Политехник коллежийн спорт зааланд, 10-рт баг Дорнод их сургуулийн спорт зааланд, 11-р багт Хэрлэн номин бизнес төвийн спорт зааланд зөвхөн амралтын Бямба, Ням гарагт, иргэдийн орох, гарах хөдөлгөөнийг зохицуулах, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулахыг зөвшөөрөв,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат-д:

2.4.Коронавируст халдвар /COVID-19/-ын үед аймгийн Засаг даргын захирамжаар томилогдон ажиллаж буй мэргэжлийн байгууллагуудын бүрэлдэхүүнтэй багуудын үйл ажиллагаанд дотоод хяналт, ажлын хэсэгтэй хамтран хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж дүгнэлтийг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

1  /М.Бадамсүрэн  
 Д.Баттулга

Гурав. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:

3.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаа буюу 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүд ажиллахад шаардагдах зардлыг АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хянуулж аймгийн Засаг даргын зөвлөлийн дараагийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.2. Шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд шаардлагатай нүүрний хаалт 84 ширхэг, комбинзон 63 ширхэг, нэг удаагийн амны хаалт 8564 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Эрүүл мэндийн газарт олгохыг,

3.3. Матад сумын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу нэг удаагийн амны хаалт 1000 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Матад сумын Засаг даргын Тамгын газарт олгохыг,

3.4. Баяндун, Булган сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд ашиглах дардас хийлгэхэд шаардагдах зардал 190,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгохыг,

Дөрөв. АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

4.1. Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт агентлагуудаас нэмэлтээр томилогдон ажиллаж байгаа албан хаагчдыг Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаа буюу 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал ажиллуулахыг зөвшөөрөв,

Тав. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:



5.1. "Эм Си Жи майнинг" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу Хөлөнбуйр сумын хяналтын цэгээр нэвтэрснээс хойш 24 цагийн дотор Дорнод аймгийн газар нутгаас буцаж гарах тохиолдолд нэвтрүүлэхийг зөвшөөрөх, нэвтэрснээс хойш 24 цаг өнгөрсөн тохиолдолд Чойбалсан хотод 7 хоног тусгаарлах тухай хариу мэдэгдэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа нарт:

5.2. "Степ голд" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу тус компанийн 63 ажилтныг Ганхэрлэн зочид буудалд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж 7 хоног тусгаарлахыг,

1.  /М.Бадамсүрэн  
2.  Д.Баттулга



Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

5.3."Мобиком" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу ажилчдыг тусгаарлахаар харилцан тохиролцсон "LUX" зочид буудалд үнэлгээ хийлгэн дүгнэлтийг аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын дараагийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг нарт:

5.4."МЭЭ" ХХК-аас "ДБЭХС" ТӨХК-д ажиллах 12 ажилтныг Дорнод аймагт нэвтрүүлж тусгаарлах тухай хүсэлтийн дагуу заасан тусгаарлах байранд үнэлгээ хийж шаардлага хангасан тохиолдолд тусгаарлах зөвшөөрөл олгохыг,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг-д:

5.5."Спейшл майнинг сервис" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Степ голд" ХХК-д ажиллах 10 ажилтныг нэвтрүүлэх тухай хүсэлтийг тодруулж аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын дараагийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,



Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг нарт:

5.6."ЭРДЭНЭДРИЛИНГ" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-д ажиллах 21 ажилтныг нэвтрүүлэх тухай хүсэлтийн дагуу Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт "Тосон-Уул" 19 дүгээр талбайн Цагдаагийн албан хаагчийн хяналтан дор баталгаа гаргуулах, давтан шинжилгээнд хугацаанд нь хамруулахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг нарт:

5.7.Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгт шалгагдаж байгаа 6 иргэнийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулж Улаанбаатар хот руу нэвтрүүлэхийг зөвшөөрөв,

 / М.Бадамсүрэн  
 Д.Баттулга

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.8."Ти Эм Би Эн" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн 4 ажилтныг нэвтрүүлэх тухай хүсэлтийн дагуу бэлтгэсэн зочид буудалд тусгаарлах тухай хариу мэдэгдэхийг,

5.9.Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн Ахмад настны амралт, сувиллын төвийн үйл ажиллагааг эхлүүлэх тухай хүсэлтийг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА



М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

*D. Battulga* Д.БАТТУЛГА